



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

“Анумаргад эрдэнэ ББСБ” ХХК-ийг
“Даймондкапитал ББСБ” ХХК-д нэгтгэхийг зөвшөөрч,
“Анумаргад эрдэнэ ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.5, Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7.7.1, 7.7.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Анумаргад эрдэнэ ББСБ” ХХК-ийг “Даймондкапитал ББСБ” ХХК-д нэгтгэхийг зөвшөөрсүгэй.
2. “Анумаргад эрдэнэ ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих бүртгэлийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Даймондкапитал ББСБ” ХХК /Т.Дэлгэрмаа/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН